

Д. Нацагдоржийн “Харанхуй хад” өгүүллэгийн бэлэгдэл утгын тухай

Ж.Отгонбаяр.МУБИС.

Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойтой Их зохиолчын мэндэлсний 100 жилийн ой давхацсан нь сонин учрал юм. Аливаа түүхэн үйл явц, их хүмүүсийн амьдралын үнэн алслах тусам об'ектив утгаа олдог гэдэг. Өөрөөр хэлбэл, хувь хүмүүсийн хийгээд цаг үеийн явцуу эрх ашгаас түүх чөлөөлөгдөж байгаа нь тэр ажээ. Энэ бол гэрч, судлаач хоёрын хэн хэн нь түүхэн үйл явцад илүү бодитой ханддаг вэ гэдэг асуултын нэгэн хувилбар хариулт билээ. Их зохиолчийн ойн эргэн тойрноо өвөрмөц содон олон ажил, арга хэмжээ зохион байгуулж байгаагаас хамгийн сонирхолтой нь түүний уран бүтээлийн өвийг нарийвчлан судлах, өргөн түмнээ түгээн дэлгэрүүлэх явдал юм.

Энэ байдал миний сонирхлыг басхүү өдөөж, хориод жилийн өмнө дипломын ажлаа энэ их хүний зохиол бүтээлтэй холбон бичсэнийг минь санагалзуулав. Цаг дэлгэрч, мэргэжил маань нэг үзэл суртлын хүлээснээс ангижирч, нээлттэй чөлөөтэй сэтгэлгээ өрнөх болсон цаг дор бусдын судалгаа, үзэл бодолд нэн хүндэтгэлтэй хандахын хамт өөрийн санаа юугаа судлаач, сонирхогч түмэнтэй хуваалцахын учир үүнийг тэрлэлээ. Энэ бол Д. Нацагдоржийн “Харанхуй хад” хэмээх хоёр хувилбараар /нөгөө хувилбар нь “Морь эрэхээр одов”/ бичигдсэн тун хачирхалтай сонин зохиолын тухайд дэвшүүлсэн таамаг санаа юм. Аливаа их хүмүүсийн нэгэн адил их зохиолч ч мундахгүй олон асуудлыг хойч үедээ үлдээжээ.

Би хэлбэрээр бичигдсэн эл өгүүллэгийн үйл явдал нь өглөөний найман цагт унтсан нойрноос арайхан сэрсэн идэр эр энэ өдрийн элдэв хэргийг бодон, дэрэн дороос өврийн дэвтрээ авч тэнд тэмдэглэсэн утга ба учир тодорхойгүй баримт сэлтээс ургуулан “Харанхуй хад”, “Ина” гэхчилэн эрт, эдүгээг улируулан эргэцүүлснээс эх авч, мөнөөх харанхуй хадны эрлээр өрнөж, эцэс сүүлдээ айдас жихүүдэс нүүрлэсэн учир битүүлэг байдалд төгсдөг.

Ийм учир битүүлэг байдлаар зохиолч юун тухай өгүүлэв гэдэг нь хариулт нэхэж буй гол асуулт юм. Эндээс л бүх асуудал үүсдэг. Ийнхүү асуудлын зангилааг тайлах гэсэн судлаачдын эрэл хайгуул өрнөсөн билээ. Зохиол бичигдсэнээр төгсдөггүй, харин эхэлдэг гэсэн санаа бол философийн герменевтикийн тулгуур зарчмуудын нэг юм. Тэгвэл “Харанхуй хад” зохиол бичигдсэнээр түүний амьдралын мөчлөг нь эхэлсэн ажээ. Дээр дурдсан асуудлын талаар өөрийн байр суурийг илэрхийлэхийн урьдал болгож зарим судлаачын тайлбарыг товч боловч авч үзэх нь зохистой гэж бодож байна. Яагаад гэвэл, би энэхүү санал дүгнэлтээ өмнөх судлаачдын таамаг, тайлбар, эрэл хайгуулын үргэлжлэл гэж үзэж байгаа юм. Тийнхүү бодоход нина, ина, чоно саарал хэмээхийн цаад утга юу байж болох талаар эргэцүүлэхдээ “болзоо тавьсан уулзах газар” гэх Харанхуй хад, Чоно Сааралын “бэлчээр” Адуун чулуу хэмээх орон ертөнцийг ч интерпретацийн гадна үлдээж боломгүй санагддаг.

Урьд өмнө хийгдсэн олон талт хайгуулын үр дүн, чиглэлийг судлаач С.Байгальсайхан тоймлон товчоолсон нь буй /С. Байгальсайхан “Харанхуй хад” өгүүллэгийн тухай. – Утгын чандмань. УБ., 2003. / Энд тэмдэглэсэнчлэн, “Харанхуй хад”, “Морь эрэхээр одов” гэсэн хоёр хувилбарыг уншсан хэн боловч хоёр өөр зохиол гэж үзэхгүй. Харин нэгэн зүйлийг хэлэхийн тулд зохиолч өөр өөр хувилбар сонгосон нь илт байна. Ийм учраас зохиол хувилбартай байгааг, басхүү төгсгөл нь өөр өөр байгааг, ерөнхий үйл явдал өөрчлөгдөхгүй байгааг онцлон сонирхох хэрэгтэй мэт санагдана. Хувилбарууд хэд болохоос

ерөнхий утга үл өөрчлөгдөн хадгалагдана гэсэн санаа бололтой. Энэ байдалтай холбогдуулан С. Байгальсайхан судлаач “ Эндээс үзэхэд зохиолч нина, ина, чоно саарал морь ч юм уу эсвэл аль нэг өөр зүйлийг эрэх, үзүүлэх, хүсэх нэгэн бодлоготой байжээ гэж үзэж болно” хэмээн дүгнэсэн / мөн тэнд, 38 дахь тал / байхад утга зохиолчын онолч Ч. Билигсайхан “ *тэр зорилго нь зохиол бичих явдал нь ч байж болох эсвэл өөрийнх нь үзэл итгэл нь ч байж болох энэ бүхэн нууцлагджээ*” / Ч. Билигсайхан. Ухаарахуй. Орчин үеийн утга зохиолын онол. УБ., 2003. 55 дахь тал / хэмээн тэмдэглэсэн байна. Зохиолын далд утгыг нээхэд түүнийг бичсэн арга барил ч чухал ач холбогдолтой байж болох юм.

Зохиолыг уран сэтгэмжийн өнгө аястай болгох явдал нь зохиолчийн гол зорилго байгаагүй болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл, далдалсан гол зүйлээ илэрхийлэх “ арга хэрэгсэл ” нь өөрөө уран сэтгэмжлэг шинжтэй байсных тэр бололтой. Харин энэ “ арга хэрэгсэл ” нь юу вэ? Зохиолыг зүүдний хэлбэрээр бичсэн гэж үздэг судлаачдын саналыг би дэмжиж байгаа юм. Энэ тухайд Д. Намдаг агсаны тайлбар нэлээд үнэмшилтэй санагддаг. Тэрээр зохиолын үйл явдлыг шинжин үзээд, энэ бол ертөнцийн бодит үйл явдал яавч биш, “ амьдралын үнэнээс хальж байна... зохиомол өгүүллэг гэж хэлж болох санж... Үүнийг би зүүд гэж үзэв. Ахин ахин унших тусам зүүд болох нь улмаар тодорно” / Д. Намдаг. Шинэ монголын шинэ театр. УБ., 1985. 162 дахь тал / гэж онцолсон буй. Зохиолын баатар хаашаа явахаа мэдэхгүй мориныхоо хандсан зүгээр баримжаалж байгаа зэрэг гол үйл явдлын өрнөлийн дотоод логик авцалдаж шүтэлцэхгүй байгаа нь ийн дүгнэхэд арга буюу хүргэнэ. Хаана байгаа хийгээд юу болохыг нь мэдэхгүй зүйлээ эрнэ гэдэг байшгүй. Энэ нь юу ч бишийг эрэхтэй агаар нэгэн болой. Миний санахад, дотоод логик төдийгүй гадаад хэлбэр нь ч уг өгүүллэгийг зүүд болохыг хэлээд өгнө. Тухайлбал, үйл явдал нь унтсан нойрноос сэрэхүй үед, өөрөөр хэлбэр, ор хөнжил дотроос эхэлдэг. “ Би буруу харж хэвтэн хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд цааш одов” гэсэн байдлаар өрнөж байна. Цаашилбал, “ сэтгэл хөдөлж, улмаар ... уяран мэлмэрч, зүүд мэт болон зэрэглэсээр агшин зуур үүргэлж”, “ тамхины үнс хэнхдэг дээр унахад гэдрэг цочин сэрэхэд”, “ сэтгэлийн дотор гулин галин байдлыг төрүүлнэ”, “ Амраг Инаг олж уулзана хэмээсэн нь харин зүүдлэн / курсив – Ж. О. / давхиж, хөндий талд төөрөх нь ч юм уу?”, “ ихэд сочсон тул нэгэнт мэдрэл зайлжээ. Нэлээд удсаны хойно сэргэж үзвээс толгойгоо нэгэн хүний дээр тавьсан буюу унтсан ба зүүдэлсэн ба гэртээ буюу хаана бүхийг мэдэхгүй сочин босож үзвээс” гэх зэргээр үйл явдлын бүхий л явцад зүүдний тухай ил, далд байдлаар өгүүлсэн байна. Мөн түүнчлэн зохиолын эх бичигт судалгаа хийсэн судлаач Ч. Жачин их зохиолчийн хожим хийсэн засварын ихэнх нь “ Морь эрэхээр одов” хувилбарт хамаарах бөгөөд эх бичгийн төгсгөл дэх “ гүнзгийгээр баясалцан амьсгалд сочин сэрвээс яруу найруулга хэмээх урмаар / амрахаар?/ бичсэн нэгэн дэвтрийг уншин хэвтэх бөгөөд эргэцүүлэн бодвоос цөм нэг зүүд ажгуу” гэсэн оруулбар нь “ Харанхуй хад” –тай холбоотой гэж үзсэнийг ч онцлон тэмдэглэж байна.

Зохиолын төгсгөлийг харахад айдас хүйдэс дунд зохиолын баатар цочин сэрж буй нь чухамдаа хар дарсан зүүднээс сэрэхийн адил байна. Амь тэмцээж, цухалдуулсан хар дарсан зүүднээс сэрэх нь чухамдаа өөрөө баясал, тайвшрал байдаг. Ийн бодоход зохиол бүхэлдээ “ зүүдний ажил” бололтой. Зүүд бол үл биелсэн хүсэл, түрэгдсэн бодол санаануудын нэхэл хатуутай шаардлага, нэг ёсондоо, ухамсаргүй дэх тэдгээрийн “ биелэл ” юм. Энэ бол зүүдний тухай Зигмунд Фрейдin тайлбар.

Д. Нацагдорж үндэс угсаа, өв соёл, нийгмийн дэвшилтэй холбогдуулан өдрийн бодол, шөнийн зүүд болж явдаг нэгэн айхтар санаагаа илэрхийлэхдээ зүүдний хэлбэрийг сонгожээ гэж бид үзэж байна. Энэ айхтар санааг заавал хэлж сануулах, улмаар бичиж үлдээх учиртай боловч шууд хэлж, бичиж болохгүй байсанд хэргийн учир оршиж байгаа бололтой. Яагаад гэдэг тухай хойно ярих болно.

Зохиол хоёр хувилбартай байгаа нь чухам юуг ч зүүдэлж болохыг, тэр тусмаа айдас, санаашрал шаналгаа, нэг ёсондоо, "харанхуй" байдлаар, эсвэл түргэдсэн ухамсар, далд хүсэл биелж, "нар гарч", "магнай тэнийж" байгаагаар зүүдэлж болдогтой холбоотой. Энэхүү зүүдний "ажлын" утга болоод буй тэр зүйл бол зохиолчийн далд хүсэл, далд ухамсар болтлоо бэтгэрсэн итгэл үнэмшил дотоод ертөнц нь юм гэж үзэж болохоор байна. Зүүд шиг уран мэргэн, "ажил нь бүтэж байдаг" орчил ертөнц өөр хаана ч үгүй. Ёстой л "барьж тавьж" байдаг шүү дээ. Уран сэтгэмжлэг байдал нь зүүдний нэгэн атрибут шинж юм. Тэнд ямар ч саад тотгор, хил хязгаар үгүй нь чухам үнэн билээ. Харин тэрхүү саад тотгоргүй байдал нь зүүдний ажлыг логик авцалдаагүй, гэнэтийн шинжтэй, чиглэл, агуулгаа огцом өөрчлөх шинжтэй болгодог.

Д. Намдаг гуай мөнөөх тайлбартаа "энэ зүүдэнд юу үзэгдэж байгаа нь тодорхой байвч чухам юу хэлэх гэж байгааг тодруулан танихад нэлээд төвөгтэй" хэмээн тэмдэглэсэн байдаг. Харин эрдэмтэн Ч. Билигсайхан "Харанхуй хад" – ыг утга зохиолын текст болох үүднээс нь бүтэц шинжлэлийн чиглэлээр судалгаа хийж болохыг дурдаад, уг өгүүллэгт тодорхой зорилгоо бусдын эрхэнд алдаж, цөхөрсөн хүний бүтэлгүй оролдлого, ядрал зовлон, сэтгэхүйн их нарийн зөрчил тусч үлдсэн байдаг гэсэн нэн сонирхолтой дүгнэлт хийжээ. / мөн тэнд, 149 дэх тал /.

Тийнхүү үргэлжлүүлэн бодвоос энэ зохиолд герменевтик болон неопозитивист арга зүйн үүднээс ч хандаж болмоор санагдана. Чухам энэ өнцгөөс, утга зохиолын текст болох талаас нь авч үзвээс энэ өгүүллэгт нэрнээс нь эхлээд дуустал ёр бэлгэдлийн шинж нэвт шингэсэн байгааг харж болмоор санагдана. Ер бэлгэдэл нь текстын утгыг нээн илрүүлэх хийгээд нууцлан далдлахдаа улам өнгө зүс оруулан амилуулдаг. Тухайлбал, "Харанхуй хад" хэмээх нэр өөрөө учир битүүлэг, чухамдаа шууд гайхашрал, бүр цочрол, зэвүүцэл төрүүлмээр бодогдоно. Энэ бол хар хад биш. Энэ хоршил хэллэгийн "харанхуй" хэмээх үг язгуур гарал нэгтэй авч яаж ч бодсон өнгө заасан "хар" хэмээх тэмдэг нэр биш. Харин гэрэл гэгээгүй, эсвэл ухвар мөчид, мунхаг гэсэн утгыг л илтгэнэ. / Их зохиолч хэд хэдэн зохиолдоо "харанхуй" хэмээх үгийг ийм л утгаар хэрэглэсэн байдаг/. Д. Нацагдорж монголчуудын бичгийн уламжлал, өв соёл, зан заншил, бэлгэдэл, дэг ёс зэргийг айхтар баримтлан зохиол бүтээлээ туурвидаг нэгэн билээ. Хад гэсэн ойлголтыг энд байгалийн утгаар нь биш, харин "нийгмийн" утгаар нь, "урагш гишгэхдээ ургаа хад", "бул хар чулуу", саад тотгор бологч зүйл, давагдашгүй дүлий цул, тодорхой бус зүйлийг тэмдэглэх төлөөлөл, бэлгэдэл утгаар хэрэглэсэн бололтой. Ийм хоёр бэлгэдэл утга бүхий үгс нийлэн нэрлэсэн болохоор энэ зохиолд ёр бэлгэдэл, муу зөн совингийн шинжтэй зүйлийн тухай өгүүлэх нь ээ.

Энэ санааг бүр лавшруулаад *долоон жилийн өмнө, бямба гариг* гэх мэт үгсийг үйлийн үзүүрт уяж өгсөн нь холын гаргалгааны учиг мэт санагдана. Тийм болохоор, долооны тооны бэлгэдэл утга монголчуудын хувьд юу болохыг тайлбарлах нь илүүц биз ээ / Энэ тухай Дулам С. Монгол бэлгэдэл зүй. Тэргүүн дэвтэр. Тооны бэлгэдэл зүй. УБ., 1999. номыг үзнэ үү/. Бямба гаригийг ч монголчууд мөн нийтлэг байдлаар цээрлэдэг, бямба гаригт сүү цагаан идээ, мал хөрөнгийг гэрээс гадагш гаргахыг буян хишиг дундарна хэмээн хориглодог, барцад нигууртай хэмээдэг. "Муу хүн үхэх нь бямба гариг" гэсэн хэлц ч байдаг.

Явах, очих газраа мэдэхгүй, унасан мориныхоо хандсан зүгийг баримжаалахыг бодвоос өгүүлж хэлэх гэж буй зүйл нь чухамдаа "морь унасан толгойгүй хүн" – ий тухай бололтой юм. Бие нь өвдсөн юм уу, царай муу байсан тухай ч зохиолд өгүүлсэн байсан билээ. Тэгээд бас өмнө хавийн зүгрүү шууд явна гээч. Зүгийн цээрийг эерүүлж, өөр зүгт мөрөө гаргаад очих зүг тийш хүлгийн жолоо залдаг учир бэлгэдэлтэй атал зохиолчийн дүрслэх нь "мордохын хазгай" гэгч ёр бэлгэ биш гэж үү?

Зохиолын баатар давхисаар хүн амьтан үл үзэгдэх зэрлэг цөл газар ирэхэд тааламжгүй бөгөөд ам цангах нь хэмжээлшгүй төдийгүй, бас сэтгэл

уйтгарлах нь хязгааргүй, нэг л "гулин галин" гэж бичжээ. Тэгж явтал үнэг юм уу, чоно юм уу нэг "бөрт" амьтан тааралдаж, тэр нь нохой байж түүний явсан зүгийг дагав ч гэх шиг. Зүүднээ үзэгдэгч үнэгний бэлгэдлийг тайлбарын судруудад ёр бэлгийн шинжтэй гэж тайлсан байх нь бий / Дулам С. Монгол бэлгэдэл зүй. Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй. Цагийн бэлгэдэл зүй. УБ., 2002. номыг үзнэ үү/. Тэгвэл аян замд явж байхад өвөр талруу үнэг орж таарвал аянчин гийчин тэр дороо нар буруу эргэж өврөөсөө гаргадаг ёс бий.

Энд ер нь л, баримжаагүйдлийн тухай, эх захгүй будилсан, "хөл толгойгоо алдсан" тухай яриад байгаа бус уу. Хүрэх газраа морины хандсан зүгээр баримжаалан гэрээс мордсон зохиолын баатар маань өдгөө эзгүй хээр шогшин буй нохойгоор баримжаа болгон явсаар нэг хар овоохойд хүрч ирнэ. Гадуур нь нэг ч мал үгүй, чухам л "хонь үгүй айлын хот харанхуй" гэмээр. Гэр доторхи байдлыг ажихад ерөнхийдөө л "хүйтэн" төрхтэй. "Хөсөг нь явчихсан" нэг эмгэн хүн үстэй дээлэнд хучаастай хэвтэж байх. Тэгээд бас зүүн өмнө хаяанд байдаг нь ч юу билээ дээ. Ямар ч монгол айлд ийм байрлал байдаггүйг эрдэмтэн С. Байгальсайхан мөнөөх бичвэртээ тэмдэглэсэн буй.

Унд цай нь гудамжны шалбааг мэт булингартай, тавьж өгсөн хоол нь хэлшгүй эхүүн үнэртэй гэснийг бодоход нэг л сэжиг хүрэм. Тэд хүмүүс харилцан ойлголцсон гэхэд ч үл итгэмээр. Эмгэн залбирал үйлдэж байгаа ч юм уу, үгүй ч юм уу, хэрвээ залбирч байна гэвэл, бурханд юм уу, онгонд юм уу / бурхантны шашинд уу, бөөгийн шашинд уу / алинд нь итгэж сүслэж хувь заяагаа даатгаж буй нь тодорхойгүй. "Бараан цохио" / нөгөө хувилбарт "Адуун чулуу" гэсэн бас нэг тодорхойгүй газар орны тухай яригдаж байна. Харин манай эцэг өвгөдийн үеэс дамжиж ирсэн ховор юм гэнэ билээ гээд боодолтой зүйлийг тахилын хавиас авч өглөө гэснийг бодоход уламжлалт соёл хичнээн үнэ цэнэтэй ч шууд утга, байгаа байдлаараа зохиогчийн итгэл үнэмшил болгоод буй "зөвхөн Нарыг хэвээр үлдээх" их өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүч болж чадахгүйг илэрхийлсэн бололтой. Эмгэний авч дамжуулсан энэ боодолтой зүйл чулуу байгаа нь, тэгээд бас хагарч буй нь лав л сайны бэлгэдэл биш дэг ээ. Хэдий тийм ч эрлийн хүн энэ чулууг онцгой өвөрмөц шинжтэй. "чулуу чулуунаас өөр" гэж үзэн, чиг зүгийг заалгах "хоёрдугаар тэмдэг" болгохоор эмгэнээс гуйж аван өвөртөлж буй нь мөнөөх өөрчлөлтөнд "энэ чулууны" үзүүлж болохуйц ач тусынх нь тухай горьдлогын оч тасраагүйг харуулах аж.

Айлын хаяанаас эхлэн чулуугаар удирдлага болгон зүглэх нь бодот амьдралд байдаггүй үйл бөгөөд харин амьдралд буулгая гэвэл мөнөөх баримжаагүйдэл л юм. Өөр юу ч биш. Зохиолын баатар цааш яваад үлэмж бартаат шавар намаг, саад бэрхшээл ихтэй, "нэгхэн ч зам мөргүй" газар оронд очно, хааяа нэг хар хэрээ үзэгдэхээс өөр амьтан үл тохиолдоно. Монголчуудад хон хэрээний тухай олон эерэг бэлгэдэл байдаг ч, энэ газар оронд, ийм цаг дор тохион үзэгдсэн хэрээ яавч сайны утга биш. "Борооны түрүүнд шороо, боохойн түрүүнд хэрээ" гэдэг дээ. Тэгээд ч төдөлгүй чоно ульж, тас нясхийх чимээ гарахад зохиолын баатрын үс босож, зүрх догдлон бие нь зарайж, өдөр дөрвөн зүгийн алин тийш явахыг гайхаж байсан бол одоо дөрвөн зүг нь хаана, хааш болохыг нэгэнт алдаад гагцхүү амиа хамгаалахыг урьдал болгодог. Айж цочих нь улам олширч, замаас нэгэнт төөрч, гагцхүү нар мандахыг хүлээнэ зэргээр бичих нь тэсч ядан бүхий айдас түгшүүртэй амьдрал. Тийм ч учраас "харанхуй хадны дунд хашралтай бөгөөд аюултай". Энэ түгшүүр айдсыг үргээж хэзээ "нар мандах нь" тодорхойгүй ч халуун итгэлд сайн цагтай учрах хүслэн байсаар ажгуу. Энэ юун тухай хар дарсан зүүд, айдас түгшүүр яриад байгааг уншигч хэдийнээ гадарлах төдийгүй, доторлоо биз ээ.

Тийм учраас эл өгүүллэгийн утгыг тайлахдаа түүнийг бичсэн 1930-аад оны үеийн их зохиолчийн хувь амьдралд тохиолдож буй элдэв төрлийн дарамт шахалт, хардалт сэрдэлтийг судлаачид анхааралдаа авдаг нь үндэслэлтэй зүйл гэж үзэж байна.

Мөн түүнчлэн нийгэм улс төрийн ээдрээ төвөгтэй нөхцөл байдлыг онцолж, "Харанхуй хад" бол улс төрийн утгатай, далд нууц санаатай өгүүллэг юм гэж үзсэн судлаач С. Байгальсайханы санааг дэмжиж, бас лавшруулмаар санагдана. Учир яагаад вэ гэвэл, Д. Нацагдорж бол яах аргагүй улс төрийн хүн, улс төрийн зүтгэлтэн байсан билээ. Тийм ч учраас тэрээр "аливаа цэрэг, улс төрийн үйл ажиллагааг нууцалсан үг хэллэг бүхий бичиг баримт зохиох, хувьсгалчдын хоорондын харилцах нууц шифр буюу код зохиох" ажилтай байсан бөгөөд аман зохиолд байгалийн үзэгдэл, юмсыг хүнчилдэг бол Д. Нацагдорж нийгэм, улс төрийн үйл явцыг "байгальчлан" нууцалсан хэмээх санаа тун сонирхолтойг зориуд тэмдэглэе / Нарантуяа Р. Савгүй их ухаантны зохиолын ил, далд утга нь улс төрийн агуулгатай. "Парламент" сонин. 1998 он, 8 сар, № 11-12 /. Түүний үйл ажиллагаа ямагт олон түмэнрүү, тэдний гэгээрэл, ухаарал боловсрол руу хандсан байдаг.

Монгол төрөөс бичиг соёлын их чадварт нь дулдуйдан Д. Нацагдоржийг "хар багаас" нь нийгэм төрийн хэрэгт хүчин зүтгүүлсэн билээ. Д. Нацагдоржийг гэрийн үеийн боловсролтой байхад нь Д. Сүхбаатар, Хатанбаатар Магсаржав, хичээнгүй сайд Цэрэндорж нартай хамт ажиллуулж байсан атлаа ид нас жагсч, "академик" боловсролтой болмогц нь төмрийн заводод орчуулагчаар ажиллуулсны учир шалтгаан тун ойлгомжтой бус уу!

Тэрээр энэ үед төрийн сайдын албыг хашаагүй ч, Монголын төрд болж буй үйл явц, бодлого түүний нүднээс далдуур, чихний нь хажуугаар өнгөрч байсан гэвэл даан ч үнэмшилгүй. Гагцхүү түүнд оролцох бололцоо, хувь Д.Нацагдоржид ногдоогүй аж. Тухайн үедээ манай оргил боловсролтой сэхээтний нэг нь тэр аргагүй мөн. Хэн ч маргахгүй. Нэгэн найрагчийн онцолсноор, Д.Нацагдорж бол "шар орхимжтой Монгол оронд шляп духдуулсан баруун европ байсан" юм.

Ийнхүү өгүүлэн буй зохиолын утгыг тайлахад намтар судлал, түүхэн тодорхойн зарчмууд чухал тулгуур болох ч, мөн эдүгээчлэх арга / "зохиолыг зохиогчоос нь илүү ойлгох" / , зохиолыг бичихэд төдийгүй тайлбарлахад ч нийгэм улс төрийн нөхцөл байдал шууд нөлөөлдгийг харгалзан үзэх учиртай. Тийм учраас зохиолын эхэнд өгүүлсэн "долоон жилийн өмнө" гэдэг бол дараахи тодруулга болж байна. Нэгдүгээрт, зохиолч ил тодорхой баримтаа гуйвуулан, чухамдаа "ор бараагүй, оготно сураггүй" байсан өмнөх цаг үе рүү зөөж аваачиж байгаа нь энд Нинагийн тухай, ерөөсөө бодот хүний тухай ярих гээгүй шүү гэдгээ анхааруулсан хэрэг. Хоёрдугаарт, зохиолд ерөөсөө долоон жилийн өмнөх буюу өнгөрсөн үйл явдлын тухай биш, харин хойш болох, эх орон, хүн ардад нүүрлээд буй аймшигт аюулыг зөгнөн мэдэрч, сэрэмжлүүлэхийн учир ёр бэлгэдлээр дамжуулан илэрхийлсэн байна. Ямар айхтар увидас совин түүнд ийнхүү шивнээв дээ. Гэхдээ үүнийг огт ойлгож болохгүй ч зүйл бас биш л дээ, өндөр зэрэглэлд боловсорсон оюун ухаан өөрийнх нь дотор "өдрийн бодол, шөнийн зүүд" болж шаналгаад байгаа асуудлыг зөн совин байдлаар нээж мэдэрсэн тохиолдол шинжлэх ухаанд цөөн биш. Бид гэхдээ энд зохиол бичигдсэнээс яг долоон жилийн хойно болсон улс төрийн хоморголсон хэлмэгдүүлэлтийг л зөвхөн онцолж хэлэх гээгүй юм. "Баруунтан, зүүнтэн", "уламжлалынхан, шинэчлэлийнхэн", "хойдынхон, урдынхан", "ламынхан, намынхан" болон хуваагдсан аймшигт байдлын гацаанаас улс орныг хэрхэн гэтэлгэх тухай асуудал бол зохиолын далд утга санаа юм.

Чухам энэ байдлаас гарах арга зам нь зохиолын баатрын эрээд буй эрлийн үзүүр бололтой. Эрэл мухардсан учраас л нийгэм улс, хүн ард бүхэлдээ харанхуй төөрөгдөлд / "Харанхуй шөнө төөрсөн юм шиг, хад ууланд суусан юм шиг" / байгаа аж. Энэ мухардлаас гарахын тулд юуны өмнө тухайн үеийн нам, төрийг, түүний удирдагчдыг, тэдний хэт яаравчилсан, үндэсний соёлыг хэт үгүйсгэсэн бодлогыг шүүн тунгаах явдал байсан бөгөөд энэ нь тэр цагт даан ч боломжгүй зүйл байж дээ. Ёстой цөвүүн цаг байж. Тийм ч учраас зохиолынхоо төгсгөлд "новелла" гэж бичсэн нь хэдийгээр уран сэтгэмж гэсэн утга мөн

боловч чухамдаа өнгөлөн далдлах зорилгоор хэрэглэсэн нууцлал үг, дахиад хэзээ ч тулгарч болзошгүй байсан мөрдөн байцаалтын урьдчилсан “ өчиг ” болов уу.

Д . Нацагдоржийн энэ өгүүллэгээс гурван жилийн дараа бичсэн “Харанхуй засаг ” жүжигтээ С. Буяннэмэх ч гэсэн тухайн цаг үеийнхээ биш, харин өмнөх үеийн төр, нийгмийн бурангуйг харуулсан байдаг. Хэдий тийм боловч жүжгийн нэр болоод дотоод агуулгаар нь утга таширлуулж битүү сануулга болгосон байхыг ч үгүй гэх газаргүй. Яагаад гэвэл, С. Буяннэмэх “ Хувьсгалт залуучуудын дуу ”, “ Монгол Интернационал”, “ Мопорын шинэ дуу ”, “Октябрийн хувьсгал ”, “ Майн нэгэн ”, “ Сүхбаатарын туг ”, “ Гайхамшигт байдал” зэрэг арав гаран зохиолдоо мөнөөх “харанхуйн” тухай өгүүлсэн нь ингэж үзэхэд хүргэж байгаа юм. Энэ утгаар авч үзвээс С. Буяннэмэхийн “ Харанхуй засаг” бол чухамдаа Д . Нацагдоржийн “ Харанхуй хад ” – ны тайлал, “ гурав дахь ” хувилбар нь ч байж болох билээ.

Их зохиолчид уг өгүүллэгийн утгыг далдлах нийгэм улс төрийн шалтгаанаас гадна бас хувь шинжтэй учир явдал байсан байж болох юм. Өөрөөр хэлбэл, зохиолч өөрөө өөртэйгөө зөрчилд орж, сэтгэлзүй, итгэл үнэмшил нь хямрах болсон байж магадгүй. Энэ тухай судлаачид нэг бус удаа тэмдэглэж байгаа нь санамсаргүй хэрэг яавч биш. Тэрээр, нэг талаас, үндэс угсаа, өв түүхээ мартаж болшгүй соёл мөн хэмээн үзэж магтан бахдан дуулдаг, нөгөө талаас, “ хуучин бүгдийг цөм халах ” гэсэн шинэчлэлийн үзлийг тээгч байсан билээ.

Бидний бодоход, “ Харанхуй хад ”- ны далд, бэлгэдэл утга ийм буюу.